



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 109

Улаанбаатар хот

“Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит
үйлдвэрийн газрын 2017 оны эдийн засгийн
үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин,
контрактын биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 2.3, 3.1, 3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, захирал Р.Будтай байгуулсан контрактын биелэлтийг “Сайн” гэж дүгнэсүгэй.

2. “Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Р.Будтай байгуулах контрактыг “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын дагуу шинэчлэн 1 (нэг) жилээр байгуулахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0061591